



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Нэр бүхий 18 хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.4. дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нэр бүхий 18 компанийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хавсралтад дурдсан нэр бүхий 18 компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 01 дүгээр сарын 13. -ны өдрийн
16 дугаар тогтоолын хавсралт



1	“Алтан шагай импекс ХААБ” ХХК
2	“Бадархундага оргил ХААБ” ХХК
3	“Батбилгэх ХААБ” ХХК
4	“Баярплант ХААБ” ХХК
5	“Вүүдсоунд ХААБ” ХХК
6	“Ивээлт-Инэл ХААБ” ХХК
7	“МЭТУ ХААБ” ХХК
8	“Өвөр таван эрдэнийн шим ХААБ” ХХК
9	“Сантланс ХААБ” ХХК
10	“Танандээж трейд ХААБ” ХХК
11	“Хаантэлмэн ХААБ” ХХК
12	“Ханбүргэд хэнтий ХААБ” ХХК
13	“Хонгорын таван эрдэнийн хишиг ХААБ” ХХК
14	“Ховд бирж ХААБ” ХХК
15	“Хөвчийн тал ХААБ” ХХК
16	“Цэц-Инвест ХААБ” ХХК
17	“Роял кашимер ХААБ” ХХК
18	“Эрхэм сүрэг ХААБ” ХХК